

БАТЛАВ:  
АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Ш. БАЯНМОНХ

*М.Б.*

УЛААНБААТАР ХОТ  
БАТЛАВ:  
ДЭЛГЭР **КОНСАЛТИНГ** ХХК-ИЙН  
ХХК  
ЗАХИРАЛ Х. ТЭРБИШ  
TTT3464-15929849  
*Х.Т.Б.*

**БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭНД ТОДОТГОЛ ХИЙХ  
АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ**

Дугаар № 05/2022

2022 оны 01-р сарын 14 өдөр

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас Амгалан дулааны станц ТӨХК –ийг төлөөлж Гүйцэтгэх захирал Ш.Баянмөнх/цаашид захиалагч гэх/нөгөө талаас Дэлгэр консалтинг ХХК-ийн захирал Х.Тэрбиш /цаашид гүйцэтгэгч гэх/хамтад нь/ цаашид талууд гэх / нар нь Монгол улсын иргэний хуулийн 343-358 дугаар зүйл, Төрийн болон Орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн Газрын 2021 оны 124 дүгээр тогтоол, 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тус тус үндэслэн дараах нөхцөлөөр харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

**Нэг. Гэрээний зорилго**

1.1 Гэрээний зорилго нь Амгалан дулааны станц ТӨХК-д **Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээнд тодотгол хийх** ажил гүйцэтгэхэд энэхүү гэрээний зорилго оршино.

**Хоёр. Гэрээний нөхцөл , хугацаа, ерөнхий зүйл**

2.1. Амгалан дулааны станц ТӨХК-д Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээнд тодотгол хийх ажлыг 2022 оны 01-р сарын 14-ний өдрөөс 2022 оны 03-р сарын 02-ны дотор хийж дуусгана. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээнд тодотгол хийх тухай дараах гурван төрлийн баримт бичгийг боловсруулах нь энэхүү гэрээний үндсэн зүйл болохыг талууд харилцан тохиролцлов.

- Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчны төлөв байдлын тодорхойлолтыг боловсруулах.
- Төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлан.
- 2022 оны Байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөг боловсруулан байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хянан батлуулах.

2.2. Гүйцэтгэгч тал нь захиалагчийн хэрэгжүүлэх төслийн талаарх Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлтийг гэрээ байгуулснаас хойш календарьн 45 /дөчин тав/ хоногт багтаан уг төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлан, үндсэн үр дүнг захиалагчийн өмчлөлд хүлээлгэн өгнө.

**Гурав. Төлбөр тооцоо**

3.1. Гэрээт ажлын үнэ нь 13,200,000 /арван гурван сая хоёр зуун мянга/-н төгрөг байхаар талууд харилцан тохиролцов. Тус үнийн дунд НӨАТ болон холбогдох татвар, хураамж, бусад

- зардлууд (зураг, бүдүүвч, экспертизийн зардал г,м) багтсан багц үнэ бөгөөд цаашид өөрчлөхгүй байхаар талууд тохиролцов.
- 3.2. Гэрээт ажлын үнийн дүнгийн 50 /тавь/ хувь буюу 6,600,000 /зургаан сая зургаан зуу/-н мянган төгрөгийг гэрээ байгуулж гарын үсэг зурснаас хойш ажлын 3/турав/ өдөрт гүйцэтгэгчид нэхэмжлэлийн дагуу ХХБ-ны 453157829 тоот дансанд шилжүүлнэ.
- 3.3. Гэрээт ажлын төлбөрийн үлдэгдэл 50 хувь болох 6,600,000 /зургаан сая зургаан зуун мянга/-н төгрөгийг гэрээт ажлыг бүрэн гүйцэтгэж дууссаны дараа, захиалагч ажлын гүйцэтгэл, тайлан материалыг гэрээнд заасан нөхцөл, чанарын шаардлага хангасан гэж үзэж хүлээн авсан өдрөөр тасалбар болгон гэрээ дүгнэсэн акт баталгаажсанаас хойш нэхэмжлэлийн дагуу 30 хоногт багтаан гүйцэтгэгчийн ХХБ-ны 453157829 тоот дансанд шилжүүлнэ.

**Дөрөв: Гүйцэтгэгчийн эрх, үүрэг**

**4.1 Гүйцэтгэгч дараах үүрэгтэй:**

- 4.1.1 Ажлыг гэрээнд заасан хугацаа, нөхцлөөр, өөрийн хөрөнгө, багаж, техник хэрэгсэл, ажиллах хүчийг ашиглан чанарын өндөр түвшинд, алдаа дутагдал, доголдолгүй хийж гүйцэтгэн, захиалагчид хүлээлгэн өгөх,
- 4.1.2 Захиалагчаас ажлын гүйцэтгэлтэй холбогдуулан санал, заавар, зөвлөмж өгвөл хүлээн авах, туслах, биелүүлэх,
- 4.1.3 Ажлыг хүлээн авах үед эсвэл гомдлын шаардлага гаргах хугацаанд гүйцэтгэсэн ажил нь эрхийн болон биет байдлын дутагдалтай, захиалагчийн шаардлагад нийцэхгүй, гэрээнд заасан зорилгоор ашиглах боломжгүй байна гэж захиалагч үзвэл гүйцэтгэгч түүний тогтоосон хугацаанд өөрийн зардлаар засах буюу шинээр гүйцэтгэх,
- 4.1.4 Ажил гүйцэтгэхтэй холбогдуулан олж авсан болон танилцаж мэдсэн захиалагчид холбогдолтой аливаа мэдээлэл, баримт материал, зураглал, тооцооллын нууцлалыг чанд хадгалах, өөрийн болон бусдын ашиг сонирхолд ашиглуулахгүй, задруулахгүй, нийтэд ил болгохгүй байх,
- 4.1.5 Ажлын гүйцэтгэлийн чанар, доголдолгүй байдлыг захиалагч болон аливаа гуравдагч этгээдийн өмнө бүрэн хариуцах,
- 4.1.6 Гэрээгээр хүлээсэн үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэхгүй, дамжуулахгүй, давхар гэрээ байгуулахгүй байх,
- 4.1.7 Ажил гүйцэтгэхтэй холбогдон захиалагчаас авсан баримт, материал, тоног төхөөрөмж (хэрэв байгаа бол)-ийг ажлыг хүлээлцэх үед захиалагчид бүрэн бүтэн буцаан өгөх.
- 4.1.8 Гэрээгээр хүлээсэн бусад үүргээ ханган биелүүлэх.

**4.2 Гүйцэтгэгч дараах эрхтэй:**

- 4.2.1 Гэрээний 3 дугаар зүйлд заасны дагуу захиалагчаас төлбөрөө шаардан авах,
- 4.2.2 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг захиалагчаас шаардах.

**Тав: Захиалагчийн эрх, үүрэг**

**5.1. Захиалагч дараах үүрэгтэй:**

- 5.1.1 Гэрээнд заагдсаны дагуу төлбөрийг төлөх,
- 5.1.2 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх,
- 5.1.3 Орон нутгийн төр, захиргааны байгууллага, иргэдийн санал, бусад бичиг баримт бүрдүүлэх

**5.2. Захиалагч дараах эрхтэй:**

- 5.2.1 Ажлыг гүйцэтгэх явцад хяналт тавих, хэдийд ч ажлын явцтай танилцан, санал, заавар, зөвлөмж өгөх,

- 5.2.2 Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэгүй, зохих ёсоор гүйцэтгээгүй бол захиалагч гэрээ нэг талын санаачлагаар цуцалж, захиалагчид урьдчилан төлсөн төлбөр, учирсан зардал (хууль зүйн болон үйл ажиллагааны зэрэг), хохирлоо нэхэмжлэн авах,
- 5.2.3 Ажлыг хүлээн авах үед эсвэл гомдлын шаардлага гаргах хугацаанд гүйцэтгэсэн ажлын гүйцэтгэл дутагдалтай, чанарын шаардлагыг хангахгүй байна гэж захиалагч үзвэл хугацаа тогтоон өгч, гүйцэтгэгчийг өөрийн зардлаар засах буюу шинээр гүйцэтгэхийг шаардах,
- 5.2.4 Хэрэв гэрээний 5.2.3 дах заалтад заасан хугацаанд уг шаардлагыг гүйцэтгэгч биелүүлэгүй бол гэрээг цуцалж, өөр гуравдагч этгээдээр уг дутагдлыг арилгуулах, гүйцэтгүүлэх бөгөөд үүнтэй холбогдон гарсан бүх зардлыг гүйцэтгэгчээр төлүүлэх,
- 5.2.5 Ажлыг чанарын өндөр түвшинд, хугацаанд нь бүрэн гүйцэтгэхийг шаардах,
- 5.2.6 Ажилд байгаа дутагдал, алдаа, бүрэн бус байдлаас үүдэн учирсан хохирол, зардлыг нөхөн төлүүлэхээр шаардах,
- 5.2.7 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг гүйцэтгэгчээс шаардах.

### **Зургаа. Хариуцлага**

- 6.1. Алданги:** Гүйцэтгэгч нь холбогдох чанарын шаардлага, гэрээний нөхцлийг бүрэн хангасан ажлыг гэрээний 2.1-д заасан хугацаанд захиалагчид актаар хүлээлгэн өгөөгүй, гэрээгээр тусгайлан хугацаа тоггоож өгсөн үүргээ тухайн цаг хугацаанд нь биелүүлэгүй, зохих ёсоор гүйцэтгээгүй бол тухайн гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгээс хугацаа хэтэрсэн хоног тутамд 0.1 хувийн алданги төлнө. Гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнг тодорхойлох боломжгүй бол гэрээний 3.1-д заасан үнийн дүнгээс тооцно.
- 6.2. Захиалагч нь төлбөрийг гэрээний 3.2 дах хэсэгт заасан хугацаанд төлөөгүй бөгөөд гэрээний 3.2-т заасан төлбөр төлөх хугацааг 30 хоногоор хэтрүүлсэн бол, тийнхүү хэтрүүлсэн өдрөөс эхлэн төлөөгүй ажлын хөлсний дүнгээс хугацаа хэтэрсэн хоног тутамд 0.1 хувийн алданги төлнө.
- 6.3. **Торгууль:** Гүйцэтгэгч гэрээг үндэслэлгүйгээр цуцалсан, гэрээний 7.1 дэх хэсгийг зөрчсөн тохиолдолд гэрээний үнийн дүнгийн 30%-тай тэнцүү хэмжээний нөхөн төлбөр төлөх бөгөөд тийнхүү зөрчснөөс захиалагч болон түүний харилцагчид учирсан аливаа зардал (хууль зүйн болон үйл ажиллагааны), хохирлыг барагдуулна.
- 6.4. **Бусад хариуцлага:** Талуудын аль нэг нь гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчснөөс нөгөө талдаа учирсан хохирол, зардлыг (гэрээний үнийн дүн, алданги, торгуулиас үл хамааран) хариуцна.
- 6.5 Захиалагчийг төлөөлж гэрээний үүргийн биелэлт, ажлын гүйцэтгэлтэй холбоотой асуудлыг “Амгалан дулааны станц” ТӨХК-ийн Зуухан цехийн дарга Э. Ариунболд хариуцан ажиллана. Утас-99727172.
- 6.6 Нийлүүлэгчийг төлөөлж гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлыг “Дэлгэр консалтинг” ХХК-ийн захирал Х. Тэриш хариуцан ажиллана. Утас-99194746.

### **Долоо. Нууцлал, мэдээллийг өмчлөх эрх**

- 7.1. Нууцлал:** Талууд гэрээг хэрэгжүүлэхтэй холбогdon харилцан солилцсон мэдээлэл, баримтын нууцлалыг гэрээ байгуулагдснаас хойш хугацаагүйгээр чанд хадгалах бөгөөд нөгөө тал зөвшөөрөл олгосон эсвэл хууль тогтоомжоор шаардсанаас бусад тохиолдолд аливаа гуравдагч этгээдэд задруулахгүй, дамжуулахгүй, нийтэд ил болгохгүй байх, гэрээнд заагдаагүй зорилгоор ашиглахгүй байхаар тохиролцов.
- 7.2. Оюуны өмч:** Талуудаас гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотойгоор ашиглагдсан мэдээлэл, баримт материал, know how, оюуны өмч, барааны тэмдэгт болон хамааралтай мэдээлэл, баримтууд нь тухайн талын эзэмшил, өмчлөлд хэвээр үлдэнэ. Энэхүү гэрээний үр дунд бий болсон аливаа мэдээлэл, материал, зураг, тайлан, дүгнэлт, оюуны өмч, барааны тэмдэгтэд хамааралтай мэдээлэл, баримтууд нь захиалагчийн өмч болно.

### **Найм. Зардал хуваарилах**

8.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол ажил гүйцэтгэхэд гарах шаардлагатай бүх зардал (тээвэр, хоол хүнс, холбоо, цахилгаан, материал хүргэлт гэх мэт)-уудыг гүйцэтгэгч бие даан, бүрэн хариуцна.

### **Ес. Маргаан шийдвэрлэх**

9.1. **Зөвшилцөх:** Гэрээг биелүүлэхтэй холбогдон гарсан аливаа санал зөрөлдөөн, маргааныг талууд зөвшилцөх аргаар шийдвэрлэнэ.

9.2. **Шүүх:** Талууд хэрэв гэрээний 9.1 дэх хэсэгт заасан аргаар маргаан, зөрөлдөөнийг шийдвэрлэж чадахгүй бол Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

### **Арав. Баталгаа**

10.1. **Бүрэн эрх:** Энэхүү гэрээнд гарын үсэг зурсан өдрийн байдлаар гүйцэтгэгч нь энэхүү гэрээг байгуулах болон тэрээний нөхцлүүдийг биелүүлэхэд шаардлагатай бүх зөвшөөрлийг эрх бүхий байгууллагаас авсан болно.

10.2. **Үнэн зөв мэдэгдэл:** Энэхүү гэрээний дагуу гүйцэтгэгчээс захиалагчид гарган өгсөн бүх баримт бичиг болон мэдээлэл, баталгаа нь бүгд үнэн зөв бөгөөд ямар нэгэн чухал фактын талаар худал мэдэгдээгүй, гэрээ үнэн зөв болоход зайлшгүй шаардлагатай аливаа чухал фактыг орхигдуулаагүй болно.

10.3. **Зөрчилдөөн байхгүй тухай:** Гүйцэтгэгч нь энэхүү гэрээгээр тохирсон нөхцлүүдийг биелүүлэх нь гүйцэтгэгчийн дүрэм, журам болон ижил төрлийн бусад баримт бичгийн нөхцөл болзолтой зөрчилдөхгүй бөгөөд эдгээр нөхцөл, болзлын дагуу аливаа хувь хүн буюу бусад байгууллага, хуулийн этгээдээс зөвшөөрөл авах шаардлагагүй. Гүйцэтгэгч нь гэрээ байгуулсан өдрөөс хойш энэхүү гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ ямар нэгэн хэлбэрээр гуравдагч этгээдэд шилжүүлэхгүй.

10.4. **Туршлага, ажиллах хүч, техникийн боломж:** Гүйцэтгэгч гэрээний дагуу ажил гүйцэтгэхэд шаардагдах дадлага, туршлага, чадвартай, ажиллах хүч, тоног төхөөрөмжтэй болно.

10.5. Захиалагчийн энэ гэрээг байгуулах үндэслэл болсон гүйцэтгэгчийн гаргасан аливаа баталгаа нь гэрээ байгуулагдсанаас хойш худал болох нь тогтоогдвол гэрээ хүчин төгөлдөр бус болно.

### **Арван иэг. Давагдашгүй хүчин зүйл**

#### **11.1. Давагдашгүй хүчин зүйл:**

11.1.1. Давагдашгүй хүчин зүйлд дайн, иргэний бослого, түймэр, үер, халдварт өвчин, газар хөдлөлт, хорио цээр, тээврийн хориг болон бусад гэнэтийн болон давагдашгүй хүчиний нөхцөл байдлыг тооцно.

11.1.2. Давагдашгүй хүчин зүйлийн нөлөөнд өртсөн тал нь нөгөө талд энэ тухайгаа нэн даруй мэдэгдэх бөгөөд тухайн хүчин зүйлийн нөлөөнд өртөөгүй өөрийн үүрэгт хамаарах үйл ажиллагааг үргэлжлүүлэн гүйцэтгэж, гэрээний хэрэгжилтэд гарсан saatlyg аль болох богино хугацаанд арилгах, үйл ажиллагааг сэргээх талаар шаардлагатай бүхий л арга хэмжээг авч ажиллана.

11.1.3. Давагдашгүй хүчин зүйлийн улмаас гэрээний хэрэгжилт нэгээс (1) дээш сарын хугацаагаар бүхэлдээ буюу хэсэгчлэн saatсан тохиолдолд шаардлагатай гэж үзвэл аль нэг тал нь нөгөө талдаа хандан гэрээг дуусгавар болгох тухай хүсэлтээ бичгээр мэдэгдэж, харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

#### **Арван хоёр. Бусад зүйл**

12.1. **Нэмэлт, өөрчлөлт:** Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг талууд харилцан тохиролцож, нэмэлт гэрээ байгуулсаны үндсэн дээр шийдвэрлэнэ.

12.2. **Санал, хүсэлт:** Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах санал, гэрээг дуусгавар болгох, хугацаанаас нь өмнө цуцлах тухай мэдэгдэл болон гэрээтэй холбогdon нэг талаас нөгөө талдаа

гаргаж буй аливаа санал, мэдэгдэл, хүсэлтийг бичгээр үйлдэж 3-аас доошгүй хоногийн өмнө нөгөө талдаа гэрээнд заасан хаягаар баталгаат шуудангаар эсвэл биечлэн хүргүүлснийг хүчинтэйд тооцно.

12.3. **Гэрээний эх хувь:** Гэрээг дөрвөн хувь үйлдэж, захиалагч тал гурван хувийг гүйцэтгэгч тал нэг хувийг авна. Хувиуд хууль зүйн хувьд адил хүчинтэй.

12.4. **Гэрээний хэл:** Гэрээг Монгол хэлээр байгуулав. Хэрвээ гадаад хэл дээрх гэрээ болон гэрээний бусад баримт бичгүүд хоорондоо зөрвөл Монгол хэл дээрх хувилбарыг хууль зүйн хувьд илүү хүчинтэй гэж үзнэ.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**  
“АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК-ИЙН  
СЭЗХ-Н ДАРГА БӨГӨӨД ЕРӨНХИЙ НЯГТЛАН  
БОДОГЧИЙН АЖИЛ ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ  
Ө. УДВАЛ  
Гарын үсэг:

ХАНГАМЖИЙН ХЭЛТСИЙН ДАРГА  
Г.ЭРДЭНЭБИЛЭГ  
Гарын үсэг:

ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА  
П. ЗОРИГОО  
Гарын үсэг:

ЗУУХАН ЦЕХИЙН ДАРГА  
Э. АРИУНБОЛД  
Гарын үсэг:


ХУУЛИЙН МЭРГЭЖИЛТЭН  
Г.САРУУЛ   
Гарын үсэг:

ГЭРЭЭ БОЛОВСРУУЛСАН:  
ХАНГАМЖИЙН МЭРГЭЖИЛТЭН  
Ш. ГАНТУЛГА   
Гарын үсэг:  
Хаяг: Монгол улс, Улаанбаатар

хот, Баянзүрх дүүрэг, 8-р хороо, УС-15-1-1

Утасны дугаар: 77111251

РД: 6021646



Хаяг: БГД 18-р хороо 4-р хороолол Ард Аюушийн

Өргөн чөлөө 44-61 тоот

Утас: 99194746

РД: 5929849

1). Ернэрийн О. Удвалын үрэгчилгээний төслийг төмөхүүр дэх сансийтай  
бонну жийн шүүхийн зөвлөөрхөөнөөг гарцаа хөвөөржүүлэх